



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/134/СТА-ТШЗ

2018 он

**Аудитын код: САГ-2018/134/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Я.Самбууням  
Утас: 261885 Цахим хаяг: [sambuunyamy@audit.gov.mn](mailto:sambuunyamy@audit.gov.mn)

Аудитор Б.Баярмаа  
Утас: 261729 Цахим хаяг: [bayarmaab@audit.gov.mn](mailto:bayarmaab@audit.gov.mn)

Ниямазон аудит ХХК  
Захирал З.Цээнээ  
Утас: 70145906 Цахим хаяг: [niyamazon\\_audit@yahoo.com](mailto:niyamazon_audit@yahoo.com)

Ахлах аудитор Ж.Батнасан  
Утас: 70145906 Цахим хаяг: [nasaa27@yahoo.com](mailto:nasaa27@yahoo.com)

Улаанбаатар хот





## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ  
Н.ЦОГБАДРАХ ТАНАА

2018.02.23 № 06/502  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.






## Үүрэг, хариуцлага


Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналтын талаар
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
13. Аудитын гэрчилгээний талаар санал дүгнэлт

## Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төв 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2018/134/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 21-ний хооронд хийхээр төлөвлөн Ниямазон аудит ХХК-ийн аудиторууд хэрэгжүүлэв.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр 1/37 дугаар албан бичгээр Ниямазон аудит ХХК-д ирүүлсэн байна.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн удирдлагад гардуулна.

## Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Шилэн дансны тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Гамшгаас хамгаалах тухай, Хувиргасан амьд организмын тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхдээ Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн эх үүсвэрийн ангилал, Төсвийн бусад мэдээллийн болон балансын дансны ангилал, 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн





зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 2017 оны 7 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглаж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

### **Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа**

Тус байгууллага үндсэн зорилго нь байгалийн голомтот, зоонозын өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулахад оршиж байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь дараах гол үндсэн үүргийг гүйцэтгэдэг:

- Төв болон орон нутгийн салбар төвүүдийн лабораторийн шинжилгээ, оношилгооны стандарт, арга зүйн зааврын хэрэгжилтэнд чанарын хяналт, үнэлгээ хийх
- Лабораторийн дотоод халдвар, эрүүл зүйн хяналтын болон үйлдвэрлэсэн тэжээлт орчин, будаг, урвалж, биобэлдмэлийн бүтээгдэхүүний чанарын хяналтын шинжилгээг хийж дүгнэлт гаргах
- Үндэсний хэмжээнд тарваган тахал, боом, галзуу, хачигт риккетсиоз, хумхаа, бруцеллёз зэрэг зоонозын өвчний лавлагаа лабораторийн тусламж үйлчилгээ үзүүлэх
- Зоонозын өвчин үүсгэгч бичил биетний өсгөвөр, омог, эерэг сорьцыг баталгаажуулах, сан ажиллуулж, баяжуулах
- Зоонозын өвчин чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааг өргөжүүлэх, зөвлөмж, эмхэтгэл боловсруулах, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт семинар, зохион байгуулах

2017 онд Эрүүл мэндийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар баталсан бүтцийн дагуу мэргэжлийн тусламжийн; захиргаа төлөвлөлт, хүний нөөц, статистикийн; нийгмийн эрүүл мэнд, сургалт, эрдэм шинжилгээний; санхүү, эдийн засаг, хангамжийн; чанар, хяналт үнэлгээ, дотоод аудитын 5 алба, 3 тасагтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Улсын хэмжээнд тарваган тахлын дархлаажуулалтыг зохион байгуулж, 16 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 25680 хүн буюу хамрагдвал зохих хүний 87.5 хувийг, боом өвчний дархлаажуулалтыг 9 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт зохион байгуулж 3471 хүн буюу 98 хувийг, энцефалитын эсрэг дархлаажуулалтыг 8 аймаг, нийслэлд нийт 8528 хүнд хийжээ.

Тайлант онд зоонозын 32 халдварт өвчний лабораторийн оношилгоо шинжилгээг хийж, байгалийн голомт хяналтын тандалтаар Завхан, Баян-өлгийн аймгийн хил орчмын нутгаас нян судлалын шинжилгээгээр тарваган тахлын үүсгэгч 12, молекул биологийн шинжилгээгээр 52 сорьцонд тарваган тахлын ДНХ, ийлдэс судлалын шинжилгээгээр 40 сорьцонд тарваган тахлын эсрэгбие, эсрэгтөрөгч илрүүлсэн байна.

Зоонозын хүний өвчлөлийн тохиолдлын үед эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг 10 удаа хийж, тандалт судалгаанд хамрагдах аймгийн тоог нэмэгдүүлж, шинжилгээгээр токсоплазмоз, бэтэг, лептоспироз, япон энцефалит, Денгийн чичрэг, Бөөрний цусархаг хам шинжит халуурал, Баруун Нилийн цусархаг чичрэг зэрэг халдваруудын эсрэгбие эерэг тодорхойлогдож, хүн амын дунд эдгээр өвчнүүдийн халдваржилт байгааг тогтоожээ.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг



бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

#### **Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднэс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 14 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Аудитын нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэх явцад гарсан зарим онцлог ажил гүйлгээнээс дурдвал дараах байдалтай байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь хууль тогтоомж, журам болон УСНББОУС-д нийцүүлсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд "бага" буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Ординат" ХХК, "Нью-Раданс" ХХК байгууллагуудын хамтран гаргасан UNICUS санхүүгийн онлайн смарт системийг ашиглан санхүүгийн тайланг боловсруулж гаргасан байна. Аудитыг гүйцэтгэхдээ Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн зөвшөөрөлтэйгээр UNICUS санхүүгийн онлайн систем болон Сангийн яамны төсвийн системд нэвтрэн орж шалгав.

#### **Тав. Материаллаг байдлын түвшин**

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2017 оны батлагдсан төсөв 1,740,022.0 мянган төгрөгийн 2.0 хувиар буюу 34,800.4 мянган төгрөгөөр урьдчилан тооцсон бөгөөд гүйцэтгэлийн шатанд өөрчлөөгүй болно.

#### **Зургаа. Дотоод хяналт**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалттай байна.

#### **Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар**





2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Эрүүл мэндийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 1,724,180.9 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансанд 179,028.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 3,090.8 мянган төгрөгийн орлого олжээ.

Үүнээс урсгал зардалд 1,740,022.0 мянган төгрөг батлагдсанаас 1,727,271.7 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 12,750.3 мянган төгрөгөөр хэмнэж, 13,209.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### **Найм. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар**

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад:

- Тус байгууллагын цахим хуудас нь бие даасан "шилэн данс цэс"-г байршуулсан бөгөөд шилэн дансандаа төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлан, 5000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 1,892,060.9 мянган төгрөгийн 21, зарлагын 118,003.7 мянган төгрөгийн 7 ажил гүйлгээг тус тус байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан байна.

### **Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар**

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, үйл ажиллагааны орлого, цалин хөлс зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 11 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 14 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 80 хувь, зардлын 60 хувь, мөнгөн хөрөнгийн 80 хувь, бараа материалын 50 хувь, үндсэн хөрөнгийн 70 хувийг тус тус эзэлж байна.

### **Арав. Гол, онцлог гүйлгээний талаар**

Тус хүрээлэнгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, орлого, зардал, бараа материал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. ЛАБ-СТА-В-3/



- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар халаалтын үзелийн гүйцэтгэчийг Эрүүл мэндийн сайдын А/286 дугаар тушаалаар шилжүүлсэн эрхийн дагуу харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, Жам ХХК-тай 2017/04 дугаартай 47,800.0 мянган төгрөгийн гэрээг 2017 оны 10 дугаар сард байгуулж, гүйцэтгэгчид шилжүүлсэн 47,349.0 мянган төгрөгөөр, ажил хүлээлцэх комиссын актыг үндэслэн их засварын зардлыг капиталжуулан бүртгэжээ.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар агааржуулалтын системийн их засварын гүйцэтгэчийг Эрүүл мэндийн сайдын А/440 дугаар тушаалаар шилжүүлсэн эрхийн дагуу харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, Термо энерги ХХК-тай 2017/05 дугаартай 72,001.4 мянган төгрөгийн гэрээг 2017 оны 12 дугаар сард байгуулж, гүйцэтгэгчид шилжүүлсэн 72,000.0 мянган төгрөгөөр, системийг ашиглалтад оруулах ажлын комиссын 17/03 дугаартай актыг үндэслэн капиталжуулан бүртгэлд тусгажээ.
- ОХУ-ын Сибирь, Алс дорнодын тарваган тахал эсэргүүцэн судлах эрдэм шинжилгээний хүрээлэнтэй байгуулсан 2017-2022 онд хэрэгжих хамтын ажиллагааны гэрээний дагуу 46,681.5 мянган төгрөгийн аппарат, тоног төхөөрөмжийг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас санхүүжүүлсэн төслийн хүрээнд 20,166.4 мянган төгрөгийн тавилга хэрэгслийг тус тус үндсэн хөрөнгийн холбогдох ангилалд бүртгэн авчээ.
- Нийслэлийн өмчийн харилцааны газар нь Зоонозын өвчин судлалын үндэсний төвтэй 2016 оны 3-р сард "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ" байгуулж, тус төвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгийг хүлээлгэн өгсөн акт үйлджээ. Тайлант онд Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2017 оны А/10 дугаар тушаалаар Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 18,319.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах, 17,424.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Өмчийн харилцааны газарт шилжүүлэхээр шийдвэрлэсний дагуу 25,398.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж үндсэн хөрөнгөөс хассан байна.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс авах санхүүжилтийн дүнгээс төвлөрүүлэх шилжүүлгийн 13,209.4 мянган төгрөгийг хасаагүй гаргасныг залруулав.
- Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 179,028.4 мянган төгрөгийн санхүүжилт орсныг нэмэлт санхүүжилтийн эрхийн дагуу захиран зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр /мянган төгрөгөөр/

Санхүүжүүлсэн байгууллагын нэр	Мөнгөн дүн
Дэлхийн эрүүл мэндийн байгууллага	143,854.4
Эрүүл мэндийг дэмжих сан	13,341.0
Байгаль орчин, уур амьсгалын сан	9,000.0
Нийслэлийн захирагчийн алба	2,367.5
Нийслэлийн онцгой комисс	244.5
Тухайн жилийн давсан орлогоос	10,220.9
<b>Дүн</b>	<b>179,028.4</b>

#### **Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар**

Аудитын явцад Зоонозын өвчин судлалын үндэсний төвд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал,



дансны болон ерөнхий журнал , ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь Эрүүл мэндийн яамны харъяа, улсын төсвөөс санхүүждэг байгууллага боловч тайлант онд Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2017 оны А/10 дугаар тушаалаар 25,398.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж үндсэн хөрөнгөөс хассан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 31 дүгээр зүйлийн 31.2 дах заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд нийцүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар Нийслэлийн өмчийн харилцааны газартай байгуулсан гэрээ эрх зүйн үндэслэлтэй эсэхийг хянуулах

### **Арван хоёр. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 25,398.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлэн давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 1 зөвлөмж өгсөн болно.

### **Арван гурав. Зөрчилгүй санал дүгнэлт**

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль , УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан /6/-ыг хавсаргав.



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах  
хаягаар харилцана уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд  
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг:  
[naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Я.Самбууням  
Утас: 261885  
Цахим хаяг: [sambuunyamy@audit.gov.mn](mailto:sambuunyamy@audit.gov.mn)

Аудитор Б.Баярмаа  
Утас: 261729  
Цахим хаяг: [bayarmaab@audit.gov.mn](mailto:bayarmaab@audit.gov.mn)

Ниямазон аудит ХХК  
Захирал З.Цээнээ  
Утас: 70145906  
Цахим хаяг: [niyamazon\\_audit@yahoo.com](mailto:niyamazon_audit@yahoo.com)

Ахлах аудитор Ж.Батнасан  
Утас: 70145906  
Цахим хаяг: [nasaa27@yahoo.com](mailto:nasaa27@yahoo.com)

### Менежментийн захидал

#### Асуудал 1 Төрийн өмчийн талаар

2018 оны 2 дугаар сар





## Менежментийн захидал

Бид аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах явдал бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий нягтлан бодогч З.Ууганцэцэг болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.



## Асуудал 1. Төрийн өмчийн талаар

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал

### ҮАГ-ын ажиглалт

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь Эрүүл мэндийн яамны харъяа, улсын төсвөөс санхүүждэг байгууллага боловч тайлант онд Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2017 оны А/10 дугаар тушаалаар 25,398.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж үндсэн хөрөнгөөс хассан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 31 дүгээр зүйлийн 31.2 дах заалттай тус тус нийцэхгүй байна.

### Эрсдлүүд

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зөрчигдөх

### ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд нийцүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар Нийслэлийн өмчийн харилцааны газартай байгуулсан гэрээ эрх зүйн үндэслэлтэй эсэхийг хянуулах

Зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2018 оны 7 дугаар сарын 1-ний дотор ирүүлэх

### Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.





**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ  
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>630,605,314.24</b>	<b>729,753,504.63</b>
33	АВЛАГА	-	2,596,287.00
335	Бусад авлага	-	2,596,287.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		2,596,287.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	630,605,314.24	727,157,217.63
351	Түүхий эд материал	557,885,114.66	635,950,382.11
35110	Тусгай зориулалттай материал	316,278,754.50	313,766,104.50
35130	Эм боох материал	241,606,360.16	322,184,277.61
354	Хангамжийн материал	72,720,199.58	91,206,835.52
35410	Бичиг хэргийн материал	3,445,016.00	7,461,451.00
35420	Аж ахуйн материал	46,702,704.12	54,826,523.06
35430	Сэлбэг хэрэгсэл	3,537,000.00	5,646,200.00
35440	Түлш, шатах тослох материал	10,568,007.70	13,195,289.70
35450	Барилгын засварын материал	5,572,090.00	7,181,990.00
35470	Бусад хангамжийн материал	2,895,381.76	2,895,381.76
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,077,767,971.45</b>	<b>1,958,719,995.84</b>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,077,767,971.45	1,958,719,995.84
392	Биет хөрөнгө	2,069,785,462.55	1,946,666,149.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,967,005,167.00	3,086,354,157.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,793,463,740.21)	(1,862,066,378.09)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	260,633,660.00	290,370,094.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(198,936,619.79)	(223,004,076.95)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,845,213,115.71	1,905,794,916.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,101,351,207.81)	(1,346,297,076.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	219,178,415.19	239,201,313.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(128,493,327.48)	(143,686,800.15)
39214	Бусад үндсэн хөрөнгө	446,551.70	446,551.76
39215	Хуримтлагдсан элэгдэл	(446,551.76)	(446,551.76)
393	Биет бус хөрөнгө	7,982,508.90	12,053,846.24
39301	Програм хангамж	17,885,567.10	25,880,567.10
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,903,058.20)	(13,826,720.86)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,708,373,285.69</b>	<b>2,688,473,500.47</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,708,373,285.69</b>	<b>2,688,473,500.47</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,708,373,285.69	2,688,473,500.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,948,935,905.49	1,948,935,905.49
51101	Өмч: - төрийн	1,948,935,905.49	1,948,935,905.49
512	Хуримтлагдсан үр дүн	202,189,996.09	182,591,433.93
51210	Өмнөх үеийн үр дүн	202,189,996.09	202,491,219.15
51220	Тайлант үеийн үр дүн		(19,899,785.22)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	557,247,384.11	556,946,161.05
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,708,373,285.69</b>	<b>2,688,473,500.47</b>





**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ  
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,816,486,962.54</b>	<b>2,187,042,734.14</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>39162332.54</b>	<b>147,496,324.14</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	11,001,384.70	13,311,815.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,001,384.70	13,311,815.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,001,384.70	13,311,815.50
122	<b>Тусламжийн орлого</b>	28,160,947.84	134,184,508.64
122001	Хандив тусламж /дотоод/	28,160,947.84	134,184,508.64
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,777,324,630.00</b>	<b>2,039,546,410.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,713,655,200.00	1,870,738,990.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,713,655,200.00	1,737,390,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		133,348,690.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	63,669,430.00	168,807,420.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,669,430.00	168,807,420.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,197,501,116.77</b>	<b>2,206,942,519.36</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,197,501,116.77</b>	<b>2,206,942,519.36</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,074,946,393.61	2,135,845,817.66
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,081,867,622.53	1,130,926,283.32
210101	Үндсэн цалин	590,216,714.31	1,061,079,535.57
210102	Нэмэгдэл	491,650,908.22	
210103	Унаа хоолны хөнгөлөлт		69,846,747.75
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	127,119,446.25	129,740,389.17
210201	Тэтгэврийн даатгал	106,488,881.52	75,265,355.20
210202	Тэтгэмжийн даатгал		8,889,654.64
210203	ҮОМШӨ-ний даатгал		22,080,136.79
210204	Ажилгүйдлийн даатгал		2,136,839.98
210205	Эрүүл мэндийн даатгал	20,630,564.73	21,368,402.56
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	61,156,986.91	79,941,913.31
210301	Гэрэл, цахилгаан	28,415,100.00	28,152,525.00
210302	Түлш, халаалт	27,772,179.00	29,379,177.00
210303	Цэвэр, бохир ус	4,969,707.91	4,024,211.31
210304	Байрны түрээс		18,386,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	77,410,428.14	83,534,318.66
210401	Бичиг хэрэг	22,395,057.29	29,320,473.00
210402	Тээвэр, шатахуун	34,098,622.00	38,422,370.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,876,803.85	3,351,818.06
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,039,945.00	8,526,510.00
210408	Бараа материал акталсны зардал		3,913,147.60
2105	<b>Нормативт зардал</b>	271,167,460.44	283,402,914.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	267,550,810.44	226,122,774.75
210502	Хоол, хүнс	2,600,000.00	56,864,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,016,650.00	395,740.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,836,200.00	7,118,400
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		149,800.00
210604	Урсгал засвар	5,836,200.00	6,968,600.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	16,447,294.00	21,821,450.00
210702	Дотоод албан томилолт	16,447,294.00	21,821,450.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,003,764.00	14,715,944.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,900,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	630,000	1,323,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	720,000	892,200.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛАГА

ЗӨГЧИЛГҮЙ  
САГААТ ДҮГЭЭЛТ



210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	153,000	166,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,478,900.00	7,872,300.00
210807	Газрын төлбөр	3,847,644.00	3,809,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200,000.00	197,144.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	74,220.00	455,500.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	418,937,191.34	384,644,204.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,671,770.00	2,512,649.94
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	416,265,421.34	382,131,554.51
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	122,554,723.16	71,096,701.70
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	81,605,100.00	57,887,255.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	81,605,100.00	17,408,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		40,479,255.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	40,949,623.16	13,209,446.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,949,623.16	13,209,446.70
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(381,014,154.23)</b>	<b>(19,899,785.22)</b>
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	0.00	0.00
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(381,014,154.23)</b>	<b>(19,899,785.22)</b>

**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ  
АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,788,326,014.70</b>	<b>1,919,509,535.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,001,384.70</b>	<b>13,311,815.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	11,001,384.70	13,311,815.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,001,384.70	13,311,815.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,001,384.70	13,311,815.50
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,777,324,630.00</b>	<b>1,906,197,720.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,777,324,630.00	1,906,197,720.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,713,655,200.00	1,737,390,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	63,669,430.00	168,807,420.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,758,914,264.70</b>	<b>1,919,509,535.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,758,914,264.70</b>	<b>1,919,509,535.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,636,359,541.54</b>	<b>1,848,412,833.80</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,081,867,622.53	1,133,522,570.32
210101	Үндсэн цалин	948,078,725.53	822,867,131.32
210102	Нэмэгдэл		151,972,439.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,000,000.00	76,774,800.00
210104	Урамшуулал	73,788,897.00	81,908,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	127,119,446.25	129,740,389.17
210201	Тэтгэврийн даатгал	127,119,446.25	129,740,389.17
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	61,156,986.91	84,486,913.31
210301	Гэрэл, цахилгаан	28,415,100.00	28,152,525.00
210302	Түлш, халаалт	27,772,179.00	33,924,177.00
210303	Цэвэр, бохир ус	4,969,707.91	4,024,211.31
210304	Байрны түрээс		18,386,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	75,442,478.85	80,098,867.00
210401	Бичиг хэрэг	20,496,550.00	27,774,840.00
210402	Тээвэр, шатахуун	37,551,593.00	41,652,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,876,803.85	3,058,818.06
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,517,532.00	7,612,788.94
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	252,351,569.00	343,355,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	244,436,569.00	276,690,100.00
210502	Хоол, хүнс	2,600,000.00	56,884,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,315,000.00	9,781,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,846,200.00	34,811,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		24,605,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		3,920,400.00
210604	Урсгал засвар	5,846,200.00	6,285,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	16,447,294.00	21,821,450.00
210702	Дотоод албан томилолт	16,447,294.00	21,821,450.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,127,944.00	20,575,944.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,900,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	630,000.00	1,323,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	720,000.00	892,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	153,000.00	166,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,478,900.00	8,165,300.00
210807	Газрын төлбөр	3,847,644.00	3,809,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200,000.00	197,144.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,198,400.00	6,022,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>122,554,723.16</b>	<b>71,096,701.70</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	81,605,100.00	57,887,255.00





213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	81,605,100.00	17,408,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		40,479,255.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,949,623.16	13,209,446.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<b>29,411,750.00</b>	<b>-</b>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<b>29,411,750.00</b>	<b>-</b>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<b>0.00</b>	<b>0.00</b>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ  
АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,948,935,905.49</b>	<b>561,244,426.73</b>	<b>579,207,107.70</b>	<b>3,089,387,439.92</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			3,997,042.62	3,997,042.62
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,948,935,905.49</b>	<b>561,244,426.73</b>	<b>583,204,150.32</b>	<b>3,093,384,482.54</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		-3,997,042.62		-3,997,042.62
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-381,014,154.23	-381,014,154.23
C08	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,948,935,905.49</b>	<b>557,247,384.11</b>	<b>202,189,996.09</b>	<b>2,708,373,285.69</b>
D01	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,948,935,905.49</b>	<b>553,250,341.49</b>	<b>202,189,996.09</b>	<b>2,704,376,243.07</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			301,223.06	301,223.06
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,948,935,905.49</b>	<b>557,247,384.11</b>	<b>202,491,219.15</b>	<b>2,708,674,508.75</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-301,223.06		-301,223.06
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-19,899,785.22	-19,899,785.22
D09	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,948,935,905.49</b>	<b>556,946,161.05</b>	<b>182,591,433.93</b>	<b>2,688,473,500.47</b>





ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ  
АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Түзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,740,022,000.00	1,727,271,713.80	12,750,286.20	99.3%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,740,022,000.00	1,727,271,713.80	12,750,286.20	99.3%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,691,714,000.00	1,678,963,713.80	12,750,286.20	99.2%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,088,903,600.00	1,084,878,570.32	4,025,029.68	99.6%
210101	Үндсэн цалин	771,888,600.00	774,223,131.32	(2,334,531.32)	100.3%
210102	Нэмэгдэл	158,332,300.00	151,972,439.00	6,359,861.00	96.0%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,774,500.00	76,774,800.00	(300.00)	100.0%
210104	Урамшуулал	81,908,200.00	81,908,200.00	-	100.0%
210105	Гэрээт ажлын хөлс			-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,668,500.00	129,740,389.17	928,110.83	99.3%
210201	Тэтгэврийн даатгал	130,668,500.00	129,740,389.17	928,110.83	99.3%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,420,600.00	66,100,913.31	5,319,686.69	92.6%
210301	Гэрэл, цахилгаан	30,460,900.00	28,152,525.00	2,308,375.00	92.4%
210302	Тулш, халаалт	35,741,000.00	33,924,177.00	1,816,823.00	94.9%
210303	Цэвэр, бохир ус	5,218,700.00	4,024,211.31	1,194,488.69	77.1%
2104	Хангамж, бараа материалын зардал	51,782,300.00	51,781,717.00	583.00	100.0%
210401	Бичиг хэрэг	1,931,800.00	4,046,088.00	(2,114,288.00)	209.4%
210402	Тээвэр, шатахуун	38,719,900.00	37,064,022.00	1,655,878.00	95.7%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,192,600.00	3,058,818.06	133,781.94	95.8%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ус	7,938,000.00	7,612,788.94	325,211.06	95.9%
2105	Нормативт зардал	285,941,300.00	285,941,300.00	-	100.0%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	276,160,100.00	276,160,100.00	-	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,781,200.00	9,781,200.00	-	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,923,300.00	33,923,300.00	-	100.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,605,500.00	24,605,500.00	-	100.0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,920,400.00	3,920,400.00	-	100.0%
210604	Урсгал засвар	5,397,400.00	5,397,400.00	-	100.0%
2107	Томилолт, зочны зардал	9,871,600.00	9,871,580.00	20.00	100.0%
210702	Дотоод албан томилолт	9,871,600.00	9,871,580.00	20.00	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,202,800.00	16,725,944.00	2,476,856.00	87%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,475,000.00		2,475,000.00	0%
210803	Даатгалын үйлчилгээ	1,323,900.00	1,323,000.00	900.00	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	892,300.00	892,200.00	100.00	100%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	166,300.00	166,300.00	-	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,315,300.00	4,315,300.00	-	100%
210807	Газрын төлбөр	3,809,500.00	3,809,500.00	-	100%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	198,000.00	197,144.00	856.00	100%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,022,500.00	6,022,500.00	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,308,000.00	48,308,000.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,308,000.00	48,308,000.00	-	100%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,408,000.00	17,408,000.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,900,000.00	30,900,000.00	-	100%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,740,022,000.00</b>	<b>1,727,271,713.80</b>	<b>12,750,286.20</b>	<b>99%</b>
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,737,390,300.00	1,724,180,853.30	13,209,446.70	99%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,737,390,300.00	1,724,180,853.30	13,209,446.70	99%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,631,700.00	3,090,860.50	(459,160.50)	117%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,631,700.00	3,090,860.50	(459,160.50)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	103.00	103.00	-	100%
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	87.00	87.00	-	100%
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	-	100%

